



ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 18 өдөр

Дугаар A/84

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.3.2, 28.1.3 заалт, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.5.5, 9.5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх газар, хэлтэс, нэгжийн дарга нарт даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Г.Анхбаяр) нарт даалгасугай.
4. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийг батлагдсан өдрөөс нийт ажилтнууд мөрдөн ажилсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.БУДБАЯР

14230011003

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Гүйцэтгэх
захирлын 2023 оны 8 дугаар сарын 18-ны
өдрийн 1/х дугаар тушаалын хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ДҮРЭМ

“Тавантолгой төмөр зам” ХХК /цаашид “Компани” гэх/-ийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн зорилго нь ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтныг сургах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, эдгээрт хяналт тавих, үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Нэг. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага

- 1.1.Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг зохион байгуулахдаа Монгол улсын хууль, Засгийн газар болон бусад эрх бүхий байгууллага, Гүйцэтгэх захирлын шийдвэр, эрх зүйн акт энэ дүрмийг удирдлага болгоно.
- 1.2.Компанийн хэмжээнд газар, хэлтэс, нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг зохион байгуулахдаа энэхүү дүрмийг мөрдөнө.
- 1.3.Компанийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг компанийн ерөнхий инженер шууд хариуцна.
- 1.4.Газар, хэлтэс, салбар нэгжийн дарга нар харьяа нэгжийнхээ хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг шууд хариуцна.
- 1.5.Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулахтай холбогдсон технологи, аюулгүй ажиллагааны болон бусад салбарын аюулгүй ажиллагааны тусгайлан заасан дүрмүүдийг дагаж мөрдөнө.
- 1.6.Компанийн хэмжээнд үйлдвэрлэл үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулна.

Хоёр. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт

- 2.1.Гүйцэтгэх захирал, ерөнхий инженер хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэгийг улирал бүр хийж, илэрсэн зөрчлийг үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.
- 2.2.Газар, хэлтсүүд харьяа салбар нэгжийн дарга хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдалд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо”-д заасны дагуу үзлэг, шалгалт хийж үр дүнг хэлэлцэн шийдвэрлэж байна.
- 2.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан нэгж нь газар, хэлтэс, салбар нэгжүүдэд өдөр тутмын үзлэг хийж объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн хяналт шалгалт хийнэ.

2.4.Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэж, тайланг жил бүрийн 7 дугаар сарын 10, дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор гарган улиралд нэг удаа зохион байгуулсан ажлын мэдээллийг Гүйцэтгэх захиралд танилцуулна.

2.5.Газар, хэлтсүүд харьяа салбар нэгжүүдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг эрсдэлийн хяналтын шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэж үнэлгээ өгч ажиллана.

2.6.Газар, хэлтэс, салбар нэгжүүд эрх бүхий байгууллагуудаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдалд явуулсан үзлэг, шалгалтын мөрөөр өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлэх үүрэгтэй.

Гурав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зааварчилгаа

3.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт нь эрх зүйн, технологи аюулгүй ажиллагааны, урьдчилсан, давтан зааварчилгааны хэлбэрээр ажлын байрны анхан шатны, өдөр тутмын, ээлжит ба ээлжит бус байдлаар ажлын байр болон танхимд хийгдэж, аюулгүй ажиллагааны арга барилыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

3.2.Ажилтанд өдөр тутмын зааварчилгаа, урьдчилсан зааварчилгаа болон давтан зааварчилгааг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөх журам”-аар зохицуулна.

3.3.Өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилтны хийж гүйцэтгэх үйл ажиллагаанд тохирсон, осолгүй ажиллахад чиглэгдсэн, болзошгүй ослоос сэрэмжлүүлсэн, газар, хэлтэс, салбар нэгжийн даргын томилсон тухайн цех, хэсгийн дарга, мастер ажил эхлэхийн өмнө 15 минутаас багагүй хугацаанд өдөр бүр бичгээр, аргачилсан байдлаар өгнө. Түүний эзгүйд албан ёсоор томилогдсон албан тушаалтан өгнө.

3.4.Нийт ажилтны сургалтыг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоо”-нд заасны дагуу зохион байгуулна.

Дөрөв. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан тогтоож, шийдвэрлүүлэх

4.1.Компанийн хэмжээнд гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан тогтоохдоо Монгол Улсын Засгийн газраас тогтоосон журмын дагуу осол, хурц хордлогыг тогтоох, судлан бүртгэх бөгөөд осол, хурц хордлогын шалтгааныг тогтоох акт, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг байгуулж ажиллуулна.

4.2.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг эрүүгийн хэрэг болон хөдөлмөрийн харилцаатай холбогдуулан шалгаж байгаа эсэхээс үл хамааран шалтгааныг нь судлах, бүртгэх, орон тооны бус комисс ажиллана.

4.3.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэн (цаашид "осолдогч" гэх)-д анхан шатны тусламж үзүүлэх, эмнэлэгт хүргэх, эрүүл мэндийн яаралтай шинжилгээ хийлгэх болон осол, хордлогын улмаас бий болсон аюултай нөхцөл байдлыг шуурхай арилган, судлан бүртгэхэд шаардагдах зардлыг компани бүрэн хариуцна.

4.4.Осолдогчтой холбогдол бүхий хохирол, нөхөн төлбөр болон бусад нийгэм хангамжийн асуудлыг Засгийн газрын 269-р тогтоол (“Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”) – оор шийдвэрлэгдэнэ.

4.5.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас бий болсон хөдөлмөрийн чадвар алдалт, түүний хувь хэмжээ, хугацааг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор шийдвэрлүүлнэ.

4.6.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлах.

4.6.1.Компани нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарах бүрд Засгийн газраас тогтоосон журмын дагуу осол, хурц хордлогыг тогтоох, судлан бүртгэх үүрэгтэй.

4.6.2.Компани нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтныг өөрийн зардлаар эмнэлэгт хүргэх, шаардлагатай үзлэг шинжилгээний зардлыг хариуцах, осол, хурц хордлогын хор уршгийг арилгах арга хэмжээг 24 цагийн дотор авна.

4.6.3.Бүлэг болон 1-ээс дээш хүний амь нас эрсэдсэн осол гарсан тохиолдолд ерөнхий инженер судлахад оролцон “Үйлдвэрлэлийн ослыг тогтоосон акт”-ыг үндэслэн хурлыг гүйцэтгэх захирал удирдан, ослын шалтгааныг хэлэлцэн цаашид авах зохион байгуулалтын арга хэмжээг шийдвэрлэнэ.

4.6.4.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хүний амь нас хохирсон тохиолдолд хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч тусгайлан дүгнэлт гаргана.

4.6.5.Галт тэрэг, хөдлөх бүрэлдэхүүнтэй мөргөлдсөн болон хөдлөх бүрэлдэхүүн замаас гарсны улмаас хүний амь нас хохирсон, гэмтсэн бол компанийн үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комисс тээврийн хяналт хариуцсан нэгжтэй хамтарч шалтгааныг хэлэлцэн цаашид авах зохион байгуулалтын арга хэмжээг шийдвэрлэнэ.

4.6.6.Шинжлэн судлах, бүртгэх үйл ажиллагаа нь мэдээлэл цуглуулах, холбогдох баримт бичиг бүрдүүлэх, шалган турших, дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, мэдээлэх, сэрэмжлүүлэг гаргах, шалтгааныг хэлэлцэн цаашид авах зохион байгуулалтын арга хэмжээг шийдвэрлэх гэсэн дарааллаар явагдана.

4.6.7.Комисс нь шаардлагатай тохиолдолд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийн талаар тухайн чиглэлээр төрөлжсөн мэргэжилтэн болон компаниас хараат бус мэргэжилтэн, шинжээч, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж болно.

4.7.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг мэдээлэх.

4.7.1.Газар, хэлтэс, салбар нэгж түүний цех тасагт ажилтан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод /цаашид осол гэх/ өртсөн тохиолдолд ажил удирдагч /ахлах, мастер, бригадын дарга, ахлах механик г.м/ нь өөрийн байгууллагын шуурхай ажил хариуцсан жижүүр, диспетчер болон шууд удирдах ажилтан, менежерт нэн даруй мэдэгдэнэ. Ингэхдээ осол болсон өдөр, цаг минут, газар, ажлын байр, осолдогчийн овог нэр, албан тушаал, осол болсон нөхцөл байдал, осолдогчийн биеийн байдал, ямар эд эрхтэн гэмтсэн зэргийг үнэн зөв мэдээлнэ.

4.7.2.Салбар нэгж /өртөө, анги, депо г.м/ -ийн шуурхай ажил хариуцсан жижүүр, диспетчер нь ослын тухай мэдээллийг аваад ерөнхий инженер, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан нэгж, газар, хэлтэс, салбар нэгжийн даргад биечлэн болон утсаар мэдэгдэнэ.

4.7.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан нэгж ажилтан осолд орсон үед анхны тусламж болон хэвтэн эмчлүүлэх, шаардлагатай үед бусад

нарийн мэргэжлийн эмнэлэгт шинжилгээ өгөх, шилжүүлэн хэвтүүлэх ажлыг зохион байгуулна.

4.7.4.Газар, хэлтэс, салбар нэгжийн дарга нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан нэгжийн дарга, ахлах ажилтанд цахим шуудангаар дамжуулахын зэрэгцээ утсаар нэмэлт мэдээлэл өгнө. Энэхүү мэдээллийг амралт баяр ёслолын өдөр, ажлын бус цагаас үл хамааран хоногийн туршид нэн даруй дамжуулна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан нэгж мэдээлэлд тулгуурлан компанийн удирдлагыг мэдээллээр хангана.

4.8.Сэрэмжлүүлэг гаргах.

4.8.1.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан үед уг ослын шалтгааныг нарийвчлан судалж, тогтоосны үндсэн дээр компанийн бусад газар, хэлтэс, салбар нэгжид ослын сэрэмжлүүлгээр мэдээлнэ.

4.8.2.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тухай сэрэмжлүүлгийг холбогдох газар, хэлтэс, салбар нэгжүүдтэй хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан нэгж боловсруулж, ерөнхий инженерээр хянуулан газар, хэлтэс, салбар нэгжүүдэд тараана.

4.8.3.Ослын сэрэмжлүүлэгт үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, осолд дөхсөн тохиолдолд гарсан үеийн нөхцөл байдал, осол болох үед хийгдсэн ажилбар, түүний дараалал, осол болоход нөлөөлсөн хүчин зүйл, шалтгаан, осолдогчийн тухай мэдээлэл, хууль, дүрэм, журмын заалт зөрчигдсөн байдал, зөрчлийг арилгах, ослыг давтан гаргахгүй байх талаар холбогдох газар, хэлтэс, салбар нэгжийн хэмжээнд өгөгдсөн хугацаатай үүрэг даалгавар тусгагдсан байна.

4.8.4.Ослын сэрэмжлүүлгийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг гарсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор гаргаж тараана.

4.8.5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан нэгжээс гаргасан сэрэмжлүүлгийн дагуу бүх газар, хэлтэс, салбар нэгжүүд ээлжит бус давтан зааварчилгаа өгч, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

Тав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт

5.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага нь компанийн бүтцийн дагуу шаталсан хэлбэртэй байна.

5.2.Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг компанийн хэмжээнд Гүйцэтгэх захирал, газар, хэлтсийн дарга нар тухайн салбар нэгжийн хэмжээнд шууд хариуцна.

5.3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг зохион байгуулах, байнгын хяналт тавих, сургалт явуулах, ослоос урьдчилан сэргийлэх үүрэг бүхий Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан нэгжтэй байна. Нэгж нь гүйцэтгэх захирлын баталсан тушаал дүрэм, журам мөн холбогдох хууль, дүрэм журмын дагуу ажиллана.

5.4.Орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц, инженерийг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан эрх зүйн баримт бичгийг үндэслэн орон тооны батлагдсан бүтцийн дагуу томилон ажиллуулна.

5.5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан инженерээр хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудалд үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

5.6.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны ажилтныг томилох, ажлаас өөрчлөх тохиолдолд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан нэгжтэй зөвшилцөнө.

5.7.Компанийн нийт ажилтны ХАБЭА-н нийтлэг эрх, чиг үүргийг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо”-нд заасны дагуу шийдвэрлэгдэнэ.

Зургаа. Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага

6.1.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг эрх бүхий байгууллагаар тогтоолгосны үндсэн дээр ажлын байрны нөхцөл аюулгүй байдлыг стандартын шаардлагад нийцүүлэн хангах арга хэмжээг хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжүүлнэ.

6.2.Барилга байгууламжийн зураг төслийг зохиох, шинээр барих, өргөтгөх, өөрчлөн засварлах, ашиглалтад өгөхдөө хөдөлмөрийн эрүүл ахуйн эрх бүхий мэргэжлийн ажилтнаар хянуулан баталгаажуулна.

6.3.”Эрүүл ахуйн шаардлага, хяналт үнэлгээ хийх журам” -аар үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл, ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх, техник зохион байгуулалтын арга хэмжээ авах, ажилчдыг хөдөлмөрийн эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байраар хангах, эрүүл ахуй, ариун цэвэр, стандартын шаардлага хангасан барилга байгууламж, ажлын байранд зориулалтын багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжөөр мэргэжлийн болон мэргэшсэн хүн, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан, батлагдсан жор, технологийн дагуу ажилчдад халуун, хүйтэн хоол, ундаагаар стандартын шаардлага хангасан ундны болон ахуйн зориулалтын усаар хангах түүнд хяналт тавих зэрэг үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

Долоо. Ажлын багаж, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлага

7.1.Ажлын багаж, хэрэгсэл нь стандартын шаардлага хангасан /шамралгүй, зориулалтын шаантагтай, бариул болон иш нь барихад тохиромжтой, цахилгааны хүчдэлээс хамгаалагдсан г.м/ зориулалтын байна.

7.2.Ажлын багаж хэрэгслийн жагсаалтыг ажлын байранд ил тод байрлуулсан байна.

7.3.Ажлын багаж нь зориулалтын тавиур, өлгүүр, шүүгээ болон үүрч явах зориулалтын савтай байна.

7.4.Хурц үзүүр, иртэй багаж нь тусгай зориулалтын хамгаалах хэрэгслээр хамгаалагдсан байвал зохино.

7.5.Тоног төхөөрөмж, машин механизм нь техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байх ба техникийн паспорттай, техникийн паспортад засвар үйлчилгээ хийсэн байдал бичигдсэн, техникийн комиссын акт хавсрагдсан байна.

7.6.Тоног төхөөрөмжийн аюултай, эргэлдэх хэсэг нь хаалт, хамгаалалтаар бүрэн тоноглогдсон байх ба засвар үйлчилгээний үед задалж, салгасан бол заавал буцааж

тавьсан байхаас гадна хориглох, анхааруулах өнгөөр ялгаж будсан, эргэлтийн чиглэлийг тэмдэглэсэн байна.

7.7.Тоног төхөөрөмж нь стандартын шаардлага хангасан хамгаалалтын газардуулгатай байна.

7.8.Суурь машин, тоног төхөөрөмж нь аюул, ослын үед цахилгаан тэжээлээс салгах, бариул болон товчлууртай байхаас гадна стандартын гал хамгаалагч, зориулалтын гэрэлтүүлэгтэй байна.

7.9.Суурь машин, тоног төхөөрөмж дээр 18 насанд хүрсэн, мэргэжлийн үнэмлэхтэй, эрүүл мэндийн үзлэгт орсон, аюулгүй ажиллагааны шалгалт өгч тэнцсэн ажилтан ажиллана.

7.10.Эргэлдэх суурь машин тоног төхөөрөмж дээр бээлийтэй ажиллахыг хориглоно. Зориулалтын ханцуйвч, нүдний шил, хошуувч хэрэглэнэ.

7.11.Суурь машин, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээг хийхдээ цэвэрлэгээний зориулалтын багс, дэгээг ашиглана. Үлээх буюу гараар цэвэрлэхийг хориглоно.

7.12.Тоног төхөөрөмж ажиллаж байх үед хөндлөнгийн этгээд ойртохоос сэрэмжлүүлсэн аюулгүйн хязгаар тогтоосон зурвас /хаалт, хамгаалалт/-тай байна.

7.13.Машин механизм, тоног төхөөрөмжийн ажиллагааг зогсоосны дараа засвар үйлчилгээ, үзлэг шалгалт хийнэ. Засвар үйлчилгээ хийж байх үед удирдлага болон цахилгаан тэжээлийг залгахыг хориглох пайз тэмдэг заавал хэрэглэнэ.

7.14.Суурь машинд /точилын/ шинэ чулуу тавьсан тохиолдолд 3 минут ажиллуулж туршина. Туршилтын үед эмтэрч ан цав гарсан, янз бүрийн дуу чимээ үүссэн тохиолдолд ажиллуулахыг хориглоно.

7.15.Чулуу /точилын/ ба тохируулгад тавиурын хоорондох зай 3 мм-ээс ихгүй байна. Чулууны хажуу хэсгээр ашиглахыг хориглоно.

7.16.Точилын суурь машин дээр ажиллахдаа нүүрний хаалт, хошуувч, чихний бөглөө зэргийг хэрэглэнэ.

7.17.Тоног төхөөрөмж суурь машины байрлах зай хананаас 1м, хоёр тоног төхөөрөмжийн хооронд 1,5 м-ээс багагүй зайтай байна.

7.18.Газар, хэлтэс, салбар нэгжүүд нь Монгол улсын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 9,10,11-р зүйлийг мөрдөж ажиллана.

7.19.Ажлын байранд болзошгүй эрсдэлийн үед мэдээ дохио өгөх, тоног төхөөрөмжийг зогсоох автомат систем тавих зэрэг техник зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.

Найм. Галын аюулгүй байдлын шаардлага

8.1.Компани нь галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гал унтраах дүрэм, журам, стандартыг хангаж ажиллах үүрэг хүлээнэ.

8.2.Галын дохиолол болон гал унтраах тусгай тоноглол, гарц, орцын зураглалыг гал гарч болзошгүй ажлын байр бүрд байрлуулан, тэдгээрийг тогтмол ажиллагаатай байлгаж, ажилтныг уг тоноглолыг ашиглаж сургасан байна.

8.3.Галын аюулгүй байдлыг хангах талаар компани, ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг Монгол улсын Галын аюулгүй байдлын тухай, Зөрчлийн тухай хуулиар зохицуулна.

Ес. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах

9.1.Компани цаг агаарын тааламжгүй нөхцөл болон үйлдвэрлэлийн физик, химийн хортой хүчин зүйлээс ажилтны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор стандартын шаардлага хангасан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах, угаах, ариутгах, цэвэрлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх болон бусад асуудлыг “Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгох, ашиглах журам”- аар шийдвэрлэнэ.

Арав. Барилга угсралт, засварын ажлын үеийн аюулгүй ажиллагаа

10.1.Барилга угсралт, засварын ажлын үед ажилтан барилгын газар шорооны, талбайн, угсралт, засварын аюулгүй ажиллагааны дүрэм, стандарт, заавар, зааварчилгааг мөрдөж ажиллах үүргийг хүлээнэ.

10.2.Талбай зохион байгуулалтын зургийг эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулсан байна. Барилгын материал, хийцүүд, тоног төхөөрөмж, өргөх механизм, ажилтны аюулгүйн замнал, тусгайлсан гарц, гүүр зэргийг батлагдсан талбай зохион байгуулалтын зургийн дагуу байрлуулж, аюулгүй ажиллагааг хангана.

10.3.Барилгын талбайд барилгын ажлыг гүйцэтгэхдээ тусгай зориулалтын хашлага, бариултай стандартын шаардлага хангасан шат, тавцан хэрэглэнэ.

10.4.Шат, тавцангийн хөлийн ивүүрийг зөвшөөрөлгүйгээр авахыг хориглоно.

10.5.Цаг агаарын тааламжгүй нөхцөлд ажиллахыг хориглоно.

10.6.Барилгын талбайд аюулгүй ажиллагааны шаардлага хангасан нийтийг хамгаалах хашаа, саравч, тор, хязгаарлах тууз, ослоос урьдчилан сэрэмжлүүлсэн заах, хориглох, анхааруулах, сануулах дохио тэмдгүүдийг үйл ажиллагаанд тохируулан байрлуулсан байна.

10.7.Цахилгааны утсыг газраас 2,5м-ээс дээш өндөрт зориулалтын баганаар дамжуулах бөгөөд төмөр шатнаас уяж бэхлэхийг хориглоно.

10.8.Шат, тавцан дээрх замыг байнга чөлөөтэй байлгахаас гадна унах нурахаас сэргийлэн хэрэглэгдэх материалыг зөв байрлуулсан байх ёстой.

10.9.Зөөврийн шат, тавцан нь стандартын шаардлага хангасан, гулгах аюулаас хамгаалагдсан резин зөөлөвчтэй байна.

10.10.Шат, тавцан дээр ажил үүрэг гүйцэтгэж байх үед тэдгээрийг хөдөлгөөнд оруулахыг хориглоно.

10.11.45⁰-аас дээш налуу шатаар авирах буюу буух үед гартаа ямар нэгэн зүйлийг барихыг хориглоно.

10.12.Ухсан шуудуу болон нүхийг хамгаалалтгүйгээр үлдээхийг хориглоно. Ухсан шуудуу, нүхийг бат бөх зүйлээр тагласан, анхааруулах тэмдэг, хязгаарлах туузаар хамгаалсан байна.

10.13.Цахилгааны оруулалтын тоноглогдсон зөөврийн хайрцаг нь стандартын шаардлага хангасан гал хамгаалагчтай, зураг схемтэй, цоожтой, угсралт нь аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байна.

10.14.Барилгын талбайд ажлын тусгай хувцасгүй, дуулга малгайгүй, хамгаалалтын бүсгүйгээр ажиллахыг хориглоно.

10.15.Барилгын ажлын явцад хамгаалалтгүй тавцан, шатны хонгил, шат, цөмөрч болзошгүй нүх зэргийг байлгахыг хориглоно.

10.16.Даацын ба хамар хананаас хучилтын хавтанг илүү гаргаж тавих, дээр нь даац хэтрүүлэн материал тавих, барилгын ханан дээгүүр явахыг хориглоно.

Арван нэг. Засвар үйлчилгээний үеийн аюулгүй ажиллагаа

11.1.Засварчин, угсралтын ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтнууд нь урьдаас төлөвлөгдсөн болон төлөвлөгдөөгүй, ажлын байранд ажилладаг учраас мэргэжлийн болон аюулгүй ажиллагааны ерөнхий дүрэм зааврыг мөрдөж ажиллах үүрэг хариуцлагыг хүлээж ажиллана.

11.2.Засварын ажил эхлэхийн өмнө ажилтан ажлын багаж хэрэгсэл бүрэн гүйцэт байгаа эсэх, хамгаалах хэрэгсэл, бүс, зөөврийн гэрэлтүүлэг, хувцасны байдалд хяналт тавьж зөрчилтэй зүйлийг арилгаж хэрэглэнэ.

11.3.Ажлын байрны ажиллах нөхцөл, зам талбай, гэрэлтүүлэг, тавиур, шат, вандан, гүүр гарц, ажил үүрэг гүйцэтгэх газрын өндөр нам зэргийг урьдчилан шалгаж аюулгүй ажиллах нөхцөл байдлыг тогтоосны дараа ажил эхэлнэ.

11.4.Тавиур нь бусад техникийн эд зүйлээс ялгагдах өнгөтэй, зарим тохиолдолд ажлын шаардлагаас хамаарч анхааруулсан оврын тэмдэглэгээтэй байна.

11.5.Тавиур нь цахилгаанаар болон механик буюу гараар шилжүүлж хөдөлгөдөг нөхцөлтэй бол баригч /тормозтой/ буюу ивүүртэй байна.

11.6.Тавиурыг хөдөлгөөнгүй байхаар байрлуулна.

11.7.Засварын ажлын зориулалттай тавиур нь ажиллахад тохирсон өндөртэй, цэвэр үзэмжтэй, өнцөг ирмэг нь хурц биш дугуй хэлбэртэй байна.

11.8.Цахилгаан болон гар багаж хэрэгслээр ажиллахдаа түүний зориулалтын хаалт хамгаалалтыг авах, хамгаалалтгүй багаж хэрэгслээр ажиллах, өөр зүйлээр орлуулан хэрэглэхийг хориглоно.

11.9.1,2м-ээс дээш өндөрт болон гүний худагт орж ажиллах үед хамгаалах бүс, олс, дуулга малгай, зөөврийн гэрэл зэргийг заавал хэрэглэх шаардлагатай.

11.10.Өндөрт ажиллах үед багаж хэрэгслийг унагахаас хамгаалсан уут сав, зориулалтын хэрэгслийг хэрэглэнэ.

11.11.Байнгын ажлын байранд ажлын багажийн жагсаалт, аюулгүй ажиллагааны зааврыг ил тод тавьсан, аргачилсан зураг бүдүүвчийг байрлуулсан байна.

11.12.Хэт өндөр дуу шуугиантай ажлын байранд чихний бөглөө, дуу тусгаарлах чихэвчийг давхар ашиглана.

11.13.Зөөврийн шатыг хананд 75⁰-ийн налуутайгаар байрлуулж гулсах хөдөлгөөнд орохгүй байхаар бэхэлж, аюулгүй байдлыг хангах ажилтан заавал байна. Ийм шатаар авирах буюу буух үедээ гартаа ямар нэгэн зүйлийг барихыг хориглоно.

Арван хоёр. Төмөр замын аюултай бүсэд ажиллах аюулгүй ажиллагаа

- 12.1.Төмөр замын аюултай бүсэд ажиллахдаа “Төмөр замын тээврийн тухай хууль”, “Төмөр замын техник ашиглалтын дүрэм”, “Төмөр замын дохиоллын журам”, “Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам”-ийг мөрдлөг болгоно.
- 12.2.Өртөө, зөрлөгийн зам дээр ажил үүрэг гүйцэтгэхдээ тухайн өртөө, зөрлөгийн аюулгүй ажиллагааны замналтай танилцсаны дараа аюулгүй ажиллагааг хангаж ажиллах буюу хэвийн үргэлжлүүлнэ.
- 12.3.Өртөө, зөрлөгийн зам дээр ажиллах, явах үеийн аюулгүй ажиллагааны замналыг тухайн өртөө, зөрлөгийн жижүүрийн байранд зурж тавьсан байна.
- 12.4.Өртөө, зөрлөгийн төмөр замаар хөндлөн гарахдаа хоёр талын хөдөлгөөнийг сайтар анхаарч магадалсны дараа 90⁰-аар эгц хөндлөн гарна.
- 12.5.Зам төмөр дээр гишгэх, суух, сумын шилжүүлгийн шилжих хэсэгт гишгэхийг хориглоно.
- 12.6.Явж байгаа галт тэрэг болон сэлгээний бүрэлдэхүүний өмнүүр урьтаж гарахыг хориглоно.
- 12.7.Цаг агаарын тааламжгүй нөхцөлд сонсох эрхтнийг халхлах, замын голоор болон овор хэмжээ баримтлахгүй явах, вагон доогуур шургаж гарахыг хориглоно.
- 12.8.Зам дээр тавигдсан салгаатай хөдлөх бүрэлдэхүүний хооронд 10м-ээс багагүй зайтай байх үед болон вагоны тусгайлсан тавцангаар гарахыг зөвшөөрнө.
- 12.9.Зэрэгцээ хөдөлгөөний үед хоёр замын хооронд аюулгүй байдлыг ханган зогсох буюу сууж өнгөрүүлнэ.
- 12.10.Өртөө, зөрлөгийн замаар хөндлөн гарах, ажиллах үедээ галт тэрэгний машинчаас өгч байгаа дуут дохио, өртөө зөрлөгийн жижүүрээс чанга яригчаар дамжуулж байгаа мэдээллийг хүлээн авч аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
- 12.11.Өртөөний болон хоорондын зам дээр байхдаа гар утас ашиглахыг хориглоно.
- 12.12.Төмөр замыг гарам, нүхэн гарцаар хөндлөн гарна.
- 12.13.Төмөр замын аюултай бүсээр зорчихдоо дохионы шар хантааз өмссөнө.

Арван гурав. Хяналт шалгалтын үеийн аюулгүй ажиллагааны шаардлага

- 13.1.Удирдах албан тушаалтан, хяналтын байцаагч, инженер техникийн ажилтнууд хяналт шалгалтын ажлын явцад болзошгүй ослоос сэрэмжлүүлэн өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх үүрэгтэй.
- 13.2.Машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны байдалд хяналтыг хийхдээ үйл ажиллагааг нь бүрэн зогсоосны дараа үзлэг, шалгалт хийнэ.
- 13.3.Машин механизмыг дур мэдэн гардан ажиллуулж шалгах, ажилтны сонор сэрэмж, анхаарлыг алдагдуулахыг хориглоно.
- 13.4.Эргэлдэж байгаа болон огтлох, зорох зэрэг механик боловсруулалтын үйл ажиллагаа явагдаж байгаа хөдөлгөөний эсрэг, харалдаа зогсохыг хориглоно.
- 13.5.Тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд үзлэг, шалгалт хийхдээ эргэх хэсгийн эргэлтийн чиглэлийн зэрэгцээ буюу хажуу талд нь хариуцагчийн хамт байрлаж шалгана.

13.6. Үзлэг шалгалтын явцад тухайн ажлын байранд унах, нурах, тэсрэх дэлбэрэх, түлэгдэх, цахилгаан гүйдэлд нэрвэгдэх, зориулалтын бус зүйлээр тагласан нүх зэрэг аюултай хүчин зүйл байгаа эсэхэд анхаарч, сонор сэрэмжтэй ажиллана.

13.7. Задгай зай хураагуурын техникийн болон ашиглалтын байдалд хяналт шалгалт хийхийн өмнө 15 минутаас багагүй хугацаагаар агааржуулах системийг ажиллуулсны дараа орохыг зөвшөөрөх ба гал гаргахыг хатуу хориглоно.

13.8. Амьсгал боогдуулж болзошгүй химийн хорт бодис, хорт хий мэдрэгдсэн сөрөг нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авсны дараа ажиллахыг зөвшөөрнө.

13.9. Цахилгааны ил задгай утсыг хамгаалах хэрэгсэлгүйгээр барихыг хориглоно.

13.11. Цахилгаан тоног төхөөрөмжийн залгуурт анхааруулах, сануулах, хориглох пайз өлгөсөн байна. Дохио тэмдгийг зөрчиж, ажил удирдагчийн зөвшөөрөлгүйгээр дур мэдэн салгах, залгахыг хориглоно.

13.12. Хорт хий тогтсон байж болзошгүй хонгил болон химийн бодис хадгалсан газарт ил гал гаргахыг хориглоно.

Арван дөрөв. Хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилчид гар утас ашиглах

14.1. Хоорондын зам, өртөөний зам парк, түр ачилтын талбай, шилжүүлэн ачих терминал, салбар замууд дээр зөрчил, дутагдал илэрсэн болон ажилтны амь нас, эрүүл мэндэд эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдлуудад дуудлага хийж мэдээлэх, баримтжуулна.

14.2. Өртөөний зам парк дээр дохиолол холбоо, зам сумын төхөөрөмж, байгууламж, хөдлөх бүрэлдэхүүний үзлэг шалгалт, засвар үйлчилгээ хийх, шорын шахалт шалгах, үзлэг шалгалтын акт материал бүрдүүлэхэд баримтжуулна.

14.3. Хоорондын зам, өртөөний зам парк, ачилтын түр талбай, шилжүүлэн ачих терминал, салаа салбар замд ажиллахад радио станц, харилцаа холбооны хэрэгсэл хүрэлцээгүй дутмаг байгаа үед галт тэрэг сэлгээний хөдөлгөөн, ачилт буулгалтын шуурхай мэдээ мэдээлэл дамжуулна.

14.4. Хоорондын замд засвар үйлчилгээний ажлын үед дохиочны үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан мэдээ мэдээлэл авах дамжуулна.

14.5. Өртөөний зам суман дээр сумын шорын шахалт шалгах ажил хийхдээ хэрэв радиостанцын хүрэлцээгүй, цэнэггүй болсон тохиолдолд галт тэрэг болон сэлгээний хөдөлгөөнгүй үед гар утас ашиглан өртөөний жижүүртэй холбогдоно.

14.6. Гар утсыг дараах тохиолдолд ашиглахыг хориглоно.

14.6.1. Түр ачилтын талбай, шилжүүлэн ачих терминалын зам талбай, салаа салбар зам дээр ачааг өргөх механизмаар зөөвөрлөн сэлгүүлж байгаа үед өргөсөн ачаан доор буюу ачааг кран, чингэлэг ачигч, өргөх зөөх механизмаар ачааг зөөвөрлөх үед;

14.6.2. Өртөөний зам парк, түр ачилтын талбай, шилжүүлэн ачих терминалын зам талбай, салбар зам дээр вагонд ачаа тээврийн үзлэг хийж ломбо, эрчлээсэн түгжээ тавих үед;

14.6.3. Хоорондын замын засвар үйлчилгээ хийх, зам суман шилжүүлэг, дохиолол холбооны төхөөрөмж байгууламж дээр засвар үйлчилгээ, үзлэг шалгалтын ажил хийж гүйцэтгэх үед;

14.6.4.Сэлгээний илчит тэргэнд бууж, суух, дохионы багана зэрэг өндөрт гарч ажил үүрэг гүйцэтгэх үед;

14.6.5.Галт тэрэгний найруулагч, туслах найруулагч, зүтгүүрийн бригад сэлгээний хөдөлгөөний үед гар утсаар ярих, дуу сонсох, тоглоом тоглох;

14.6.6.Хөдлөх бүрэлдэхүүнд техникийн үзлэг шалгалт хийх үзлэгийн сувагт ажиллах үед;

14.6.7.Өртөөний зам суман дээр шорын шахалт шалгах үед зэргэлдээ замаар галт тэрэг болон сэлгээний ажил хийгдэх үед.

14.7.Өртөөний зам парк, түр ачилтын талбай, шилжүүлэн ачих терминалын зам талбай, салаа салбар зам, хөдлөх бүрэлдэхүүн, вагон засварын зам, сувагт ажиллахдаа хөдөлмөрийн болон галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлаар илэрсэн үл тохирол, үзлэг шалгалтыг баримтжуулахаас бусад тохиолдолд гар утсаар тоглох, дуу сонсох зэргээр ашиглаж байгаа тохиолдолд журмыг зөрчсөнд тооцож арга хэмжээ авхуулах саналыг удирдлагад хүргүүлнэ.

Арван тав. Албан томилолтоор явж ажиллах үеийн аюулгүй ажиллагаа

15.1.Албан томилолтоор ажиллах үедээ ажилтан өөрийн аюулгүй байдлыг хариуцан, хангаж ажиллах бөгөөд хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод зааснаас өөр ажил үүргийг албан ёсны шийдвэргүйгээр гүйцэтгэх, ажлын цагаар дур мэдэн өөр тийш явах, сэлгүүцэх, өөр ажил үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

15.2.Ажилтан ирэх ба буцах үедээ дур мэдэн явуулын тээврийн хэрэгсэлд суух, замын хөдөлгөөний дүрэм зөрчих, ачаатай машин, бүрэн бус техник хэрэгслээр зорчихыг хориглоно.

15.3.Албан томилолтоор баталсан удирдамжаар зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгслээр явж ажил үүрэг гүйцэтгэнэ. Томилолтоор очиж ажиллах орон нутаг, үйлдвэрийн газар, өртөө, депо, анги, объектын аюулгүй ажиллагааны онцлог, аюулгүйн замнал, гарц, тухайн объектод хамгаалах хэрэгсэл зэргийг хэрхэн хэрэглэх зааварчилгааг холбогдох албан тушаалтнаас авна. Хүрэлцэн очсон газар, объект, тоног төхөөрөмжийн байдалтай бүрэн танилцсаны дараа ажлаа эхэлнэ.

15.4.Авто тээврийн хэрэгслээр зорчих:

Авто тээврийн хэрэгсэлд бууж суухдаа бариулаас барьж яаралгүй буух газраа сайтар харж бууна. Хонхорхой, хотгор, гүдгэр, элдэв, хатуу биет, цахилгаан шит, худаг, нүх гэх мэт зүйл дээр гишгэх, тээглэх, унах зэргээр хөл гар биеийг гэмтээхээс болгоомжил.

15.4.1.Авто тээврийн хэрэгсэл бүрэн зогссон үед машинаас бууж, сууж байх ба авто хэрэгслээс зүүгдэж явах, хөдөлгөөн бүрэн зогсоогүй үед бууж, суух зэргийг хатуу хориглоно.

15.4.2.Авто тээврийн хэрэгслийн цонхоор толгой, гар, бусад эд зүйл ил гаргахыг хориглоно.

15.4.3.Авто тээврийн хэрэгслийн цонхоор хог болон эд зүйл хаяхыг хориглоно.

15.4.4.Хүчтэй салхи шуурга, бороо, цас орох, үзэгдэл муутай үед авто тээврийн хэрэгслийг зогсооно.

15.4.5.Авто тээврийн хэрэгслээр явж ажиллахдаа зөвшөөрөгдсөн хурд, торомз, дуут дохионы хэвийн ажиллагаа, аюулгүйн бүс хэрэглэх болон бусад аюулгүй байдлыг хангаж ажиллана.

15.4.6.Авто тээврийн хэрэгсэл түр зогсох үед бууж, суухдаа авто замын зорчих хэсэггүй тал руу бууж, сууна.

15.4.7.Авто зам хөндлөн гарахдаа хоёр талын хөдөлгөөнийг магадалсны дараагаар замыг эгц хөндлөн гарна.

15.5.Төмөр зам дээр ажил хийж байх үед галт тэрэг 400м-ээс багагүй зайд ойртон ирэхээс өмнө ажлаа зогсоож, багаж хэрэгслээ бүрэн гаргасны дараа захын зам төмрөөс 2м-ээс багагүй зайд холдож, өөрийн аюулгүй байдлыг ханган, галт тэргийг угтаж өнгөрүүлнэ.

15.6.Салхи, манан будан зэрэг цаг агаарын тааламжгүй нөхцөлд төмөр зам дээр ганцаараа ажиллахыг хориглох ба онцгой сонор сэрэмж, анхаарал болгоомжтой ажиллах хэрэгтэй.

15.7.Барилгын давхаргуудад байрлуулсан галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, аюулаас аврах гарцын бүдүүвч зурагтай танилцсан байна.

15.8.Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл болон усан хангамжийн тоног төхөөрөмжийг шаардлагатай үед ажиллуулах арга, дадлагыг эзэмшсэн байна.

15.9.Гал түймрийн аюул гарахаас урьдчилан сэргийлэн сонор сэрэмжтэй ажиллаж, болзошгүй аюул ослын ямар нэг шинж тэмдэг илэрвэл яаралтай холбогдох байгууллага, албан тушаалтнуудад мэдэгдэнэ.

15.10.Зөвшөөрөгдөөгүй газар тамхи татах, ил гал гаргахыг хориглоно.

15.11.Албан томилолтоор ажиллахдаа ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглэсэн байвал зохино.

15.12.Албан томилолтоор ажиллахдаа зөв хооллох, цаг агаарын байдалд тохируулан хувцаслана.

15.13.Албан томилолтоор ажиллах хугацаанд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглоно.

Арван зургаа. Хот хооронд зорчих үеийн аюулгүй ажиллагаа

16.1.Жолоочийн аюулгүй ажиллагаа:

16.1.1.Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг баримтлан ажиллана.

16.1.2.Аялалд гарахын өмнө хувийн болон техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна.

16.1.3.Мансууруулах бодис, согтууруулах ундаа, тайвшруулагч бодисын найрлагатай эм, бүтээгдэхүүн хэрэглэсэн болон тээврийн хэрэгсэл жолоодох чадамжгүй ядарсан үед автомашин жолоодохыг хатуу хориглоно.

16.1.4.Тухайн тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй хүнээр жолоо бариулахыг хориглоно. Үүсэх үр дагавар, хариуцлагыг тус тээврийн хэрэгслийн жолооч өөрөө хариуцна.

16.1.5.Жолооч нь замын хөдөлгөөнд оролцохдоо гар утас болон бусад анхаарал сарниулах зүйлсийг ашиглахыг хориглоно.

16.1.6.Тээврийн хэрэгслийн хурдыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэх, шалтгаангүйгээр хэт удаан явах, огцом зогсох, хөдөлгөөн саатуулахыг хориглоно. Жолооч удирдлагын хүрдийг заавал хоёр гараар барьж явна.

16.1.7.Тээврийн хэрэгслийн суудлын тоогоор зорчигчдыг суулгаж суудлын бүсийг заавал зүүлгэсний дараа хөдөлгөөнийг эхлүүлнэ.

16.1.8.Зорчигчийг тээврийн хэрэгсэлд бууж, суух үед зөвшөөрөгдсөн зогсоолд зогсож, гүйцэд бууж, суусны дараа хөдөлнө.

16.1.9.Шатахуун түгээх газар болон шатах, тослох материалын ойр орчимд ил гал гаргах, тамхи татахыг хатуу хориглоно.

16.1.10.Тээврийн хэрэгсэлд гал унтраах багаж хэрэгслийг байнга байлгаж, зориулалтын бус зүйлд ашиглахгүй байна.

16.1.11.Шаардлагатай тохиолдолд засвар, үйлчилгээг хийхдээ автомашины мотор хөдөлгүүрийг бүрэн зогсоож, ивүүр тавьж, хөдөлгүүрийг бүрэн унтраасны дараа засварын ажлыг эхлүүлнэ.

16.1.12.Жолооч ууж байгаа ундаа, усны саваа зориулалтын сав тогтоогчид байрлуулах /савыг өвдгөн дээр болон суудал доор тавихыг хориглоно./

16.2.Зорчигчийн аюулгүй ажиллагаа:

16.2.1.Зорчигч хуваарилагдсан тээврийн хэрэгсэлд сууж зорчих ба нэгдсэн журмаар хөдөлнө.

16.2.2.Тээврийн хэрэгслээр зорчихдоо суудлын бүсийг заавал зүүсэн байна.

16.2.3.Биеийн байдал хэвийн бус, толгой эргэх, дотор муухайрах, зүрх дэлсэх зэрэг шинж тэмдэг илэрсэн тохиолдолд жолоочид мэдэгдэж зорчих хөдөлгөөнийг түр зогсоож болно.

16.2.4.Тээврийн хэрэгслээс бууж суухдаа зөвхөн замын хашлага, хөвөөтэй тал руу бууж, сууна.

16.2.5.Орон нутгийн замд түр зогссон үед зам хөндлөн гарах бол 2 талаас автомашины хөдөлгөөнийг нягталж, хөдөлгөөнгүй тохиолдолд гарна.

16.2.6.Ажилтан нийтийн тээврийн хэрэгслээр зорчих үед архи согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглоно.

16.2.7.Жолоочийн биеийн байдалд зорчигч нар хяналт тавьж, жолооч нойрмоглох, хэт ядарсан тохиолдолд жолоочийг амрааж, түр зогсоох арга хэмжээ авна.

Арван долоо. Бусад зүйл

17.1.Энэ дүрмийг зөрчсөн ажилтан Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.

17.2.Энэхүү дүрмээр шууд зохицуулаагүй бусад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг зохицуулахтай холбогдсон технологи, аюулгүй ажиллагааны тушаал, заавар болон бусад салбарын аюулгүй ажиллагааны дүрмүүдийг тусгайлан дагаж мөрдөнө.

17.3.Энэхүү дүрмийг батлагдсан өдрөөс эхлэн компанийн нийт ажилтнууд дагаж мөрдөнө.

.....ооо.....